



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/675

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Баттулга (ГЮ76031319)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 16 дугаар гудамж 1612 тоотод байршилтай 6308002809 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 600 м2 газрыг 889 м2 болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зураглалын дагуу газрын хэмжээг өөрчилсүгэй.

2. Б.Баттулгатай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны А/287 дугаар захирамжийн Б.Баттулгатай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ